



СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№241 /450/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.01.06

Цаг үе, үйл явдал

ГУРВАН ТАЛТ УУЛЗАЛТЫН ХҮРЭЭНД ...



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Батлан хамгаалахын сайд нарын хамтарсан 2020 оны А/70-А/58 дугаар тушаалаар батлагдсан "Цэргийн алба хаагчдад мэргэжил, ур

чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулах журам"-ын хүрээнд хугацаат цэргийн алба хаагчдад барилгын өргөн мэргэжил олгох сургалтыг 2022 оны 01 дүгээр сарын 16-ны өдрөөс зохион байгуулахаар шийдвэрлээд байна.

Уг ажлын хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын захирал Б.Батцэцэг, Техник, технологийн политехникийн коллежийн захирал Ц.Баярмаа, Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн удирдлага оролцсон гурван талт уулзалтыг зохион байгуулав. Уулзалтын эхэнд хугацаат цэргийн алба хаагчдад барилгын өргөн мэргэжлийг олгох сургалтын ач холбогдол, үр дүн, гүйцэтгэсэн бүтээн байгуулалтын ажил болон өөрийн хүсэлтээр ахлагчийн албанд томилогдон барилгын мэргэжлийн ахлагчийн бүрэлдэхүүний нөхөн хангалтыг нэмэгдүүлж

байгаа талаар товч танилцуулгыг тэргүүн ахлагч А.Цэрэнтогтох танилцуулав.

Дараа нь энэхүү сургалтын стандарт, хөтөлбөр, боломж, хамтын ажиллагааны талаар Техник, технологийн политехникийн коллежийн сургалтын менежер Н.Мягмардорж дэлгэрэнгүй танилцуулга хийсэн юм.

Мөн энэ үеэр Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтын захирал Б.Батцэцэг Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн Мод үржүүлгийн газарт ажиллах байнгын бүрэлдэхүүн болон хугацаат цэргийн алба хаагчдад богино хугацааны Ойжуулагчийн сургалтыг зохион байгуулсан ба цаашид үнэмлэх олгох саналыг дэвшүүлсэн зэрэг өндөр ач холбогдолтой уулзалт боллоо.

Тэргүүн ахлагч А.ЦЭРЭНТОГТОХ

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-15	-24

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
36	22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.465	3.471
EUR	3.670	3.690
CNY	502	506
RUB	46.70	47.70
JPY	26	26.35
KRW	2.76	2.80

ЗУРХАЙ



2022.01.06 / БААСАН ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 15

**ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА САР
ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ
ХАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Өлзийтэй сайн

Наран ургах, шингэх:

08.41-17.14

Барилдлага:

Идэр

Шүтэн барилдлага:

Тийн мэдэхүй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд зэрэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, эм засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг дарахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олдох, баруун нүд татвал тэмцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрмөс татвал үг, асуулт болно.

НИЙСЛЭЛИЙН 2022 ОНЫ "ТЭРГҮҮНИЙ ЦЭРГИЙН ШТАБ"-ААР...



Багануур дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб нь 2021 онд дүүргийнхээ "Тэргүүний хэлтэс"-ээр шалгарсан бол өнөө жил ч тус амжилтаа бататган "Хошой тэргүүний хэлтэс"-ээр шалгарчээ.

Түүнчлэн Батлан хамгаалахын сайдын Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээ, БНД-ийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Цэргийн штабын 2022 оны цэргийн сургалт, бэлтгэлийн нэгдсэн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангасан байна. Үүний зэрэгцээ Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас 2022 онд дэвшүүлсэн "Батлан хамгаалах хууль тогтоомж-бэлэн байдлын бэлтгэлжилтийн жил"-ийн зорилгыг амжилттай биелүүлж, 2022 оны үйл ажиллагааны үр дүнгээр "Бүрэн хангалттай" үнэлэгдэж Нийслэлийн 2022 "Тэргүүний цэргийн штаб"-аар шалгарсан бахархам амжилтаар шинэ оноо угтаж буй аж.



"МИГ-29УБ" ОНГОЦНЫ ЗАГВАРЫГ ТӨРИЙН СОЁМБОТОЙ НЬ ДУУРАЙЛГАН УРЛАЖЭЭ



Энэ удаагийн "Хобби" буланд кино зураач Цагаанзагасын Түмэнхүүг онцолж байна. Ц.Түмэнхүү нь кино зургийнхаа хажуугаар хоббигоороо байлдааны техник, зэвсэглэлийг пластикаар дуурайлган "бүтээгч" залуу. Түүний хамгийн сүүлд бүтээсэн "МиГ-29УБ" сөнөөгч онгоцны загвар нь залуусын анхааралд өртөж, худалдаж авах гэсэн эрчүүд олноор гарч ирэв.

Загварынхаа тухай ярихдаа "2009 оноос хойш пластик дуураймал загварыг сонирхох болсон. Ажлынхаа хажуугаар хийдэг болохоор бусдад харьцуулахад олон биш ч гэсэн Монгол Улсын Зэвсэгт хүчинд ашиглагддаг байлдааны техник, зэвсэглэлээс цөөнгүйг нь дуурайлган "бүтээсэн" байна. Тэр дундаа цэргийн нисэх

талдаа хийсэн бүтээл нь илүү олон. Зэвсэгт хүчний агаарын цэргийнхэн ч надад захиалж, хийлгэх нь бий. Хамгийн сүүлийн бүтээл нь "МиГ-29УБ" байлдааны сөнөөгч онгоцны загвар. Монгол Улсын Зэвсэгт хүчний агаарын цэргийн зоригт хөвгүүд буюу хошууч Б.Батболд, ахмад Д.Гэлэжамц, ахлах дэслэгч Б.Хэрлэн нарыг анх удаагаа эх орныхоо хөх тэнгэрт хөөрөх үйл явдлыг хувь тохиолоор би үзэж таарсан. Дэргэдээс нь. Маш их бахархсан. Эх орныхоо цэлмэг тэнгэрт дүүлэн нисэх "МиГ-29УБ" онгоцны загварыг хийх сэдэл тэгж л төрж, дөрвөн сар орчмын хугацаанд гүйцэтгэсэн. Материалыг нь гаднын орноос захиалдаг болохоор хугацаа бага зэрэг зарцуулагддаг л даа. Бүтээлээ хийсэн тухай социал хуудаснаа оруулсны маргааш нь Зэвсэгт

хүчний 303 дугаар ангийн захирагч "Сайхан бүтээл болж, манай ангид байх ёстой загвар байна" гээд худалдаж аваад явсан" гэлээ.

Тэрээр танк, хуягт техник, нисэх онгоц, автомашин буюу бусад гэсэн гурван төрлөөр урладаг бөгөөд бүтээлийн овор хэмжээ, чимхлүүр ажлаас хамааран 7 хоногос нэг жил хүртэлх хугацаа зарцуулдаг байна. Пластик дуураймал загвар зохион бүтээх нь дэлхийд тэр дундаа Европын орнуудад үндэсний спорт болтлоо хөгжсөн бол манайд зөвхөн эхэлж байгаа ч залуус өөрөөсөө мөнгө харамлалгүй эх загварыг нь захиалан авчруулдаг, бүтээлийн 80 гаруй хувь байлдааны техник, зэвсэглэл эзэлдэг тухай Ц.Түмэнхүү ярилаа.

Ахмад Д.БОЛОР

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 667,134,364

Эдгэрсэн

Нийт: 638,814,527

Нас барсан

Нийт: 6,706,275

Цаг үе, үйл явдал

2022 ОНЫ ТЭРГҮҮНИЙ ГЭРЭЭТ ЦЭРЭГ, БАЙЛДАГЧ ШИНЭ-АВАРГЫН ЭРДЭНЭ-ОЧИР

"Гэрээт цэрэг-Гэрэлтэй алба" гэдгийг Зэвсэгт хүчний 110 дугаар ангийн Барилгын материал үйлдвэрлэлийн ротын бетон хийцийн тасгийн блокчин, гэрээт цэргийн алба хаагч, байлдагч Ш.Эрдэнэ-Очир өнөөдөр үлгэрлэн харуулав.

Зэвсэгт хүчний тэргүүлэгч офицер, ахлагч, ажилтан албан хаагчидтай зэрэгцэн шагнагдаж, цэргийн гэрээт алба хаагчдад боломж бололцоо байдгийг онжавууддаа нотлон харууллаа.

Байлдагч Ш.Эрдэнэ-Очир хугацаат цэргийн албаа Өмнөговь дэх дугаар ангид хааж дуусаад Зэвсэгт хүчний 110 дугаар ангид цэргийн гэрээт алба хаагчаар үргэлжлүүлэн нэгдсэн байна.

Тэрээр Орхон аймгийн Баян-Өндөр сумын харьяат, эхээс зургуулаа. Айлын том хүү. Зэвсэгт хүчний 2022 оны тэргүүний цэргийн гэрээт алба хаагч болсон баярт мэдээгээ хамгийн эхэнд аав Ц.Шинэ-Аварга, ээж Д.Болор-



Эрдэнэ, найз охин Б.Адъяадолгор нартаа дуулгасан гэнэ.

Аавынх нь содон нэрийн тухай сонирхоход "1975 оны сар шинийн баяраар өвөө, эмээ хоёр нь буюу тухайн үеийн залуу хосууд нутгаасаа улсын аварга болсон малчин айлд өглөө эртлэн золгохоор очиж. Бүсгүй нь өнөө маргааш төрөх дөхсөн тулгар гэдэстэй. Гэтэл бүсгүй гэнэт өвдөж, эмнэлэг явж амжилгүй төрсөн учир "Шинэ-Аварга" гэдгийг нэрийг хайрласан түүхтэй. Аваргууд бяцхан хүүг манай гэрийн эзэн шиг яваарай" гэж нэр хайрлаж, тэр цагаас хойш ойр дотно явсан тухай сонирхууллаа.

Байлдагч Шинэ-Аваргын Эрдэнэ-Очирын мөрөөдөл офицер болох бөгөөд үүний тулд хичээж буйгаа онцлон өгүүлж, цэргийн гэрээт алба хаагчдад бүтээн байгуулалтад оролцох, энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, дотоод, гадаад сургалт дамжаанд хамрагдах боломж байдгийг дамжууллаа.

"ЦЭРГИЙН ГЭРЭЭТ АЛБА ХААГЧ БИД Ч ГЭСЭН АЖИЛ АЛБААРАА МАНЛАЙЛЪЯ"



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн 2022 оны "Тэргүүний цэргийн гэрээт алба хаагч"-аар Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн Инженер-сапёрын ротын тасгийн захирагч дэд түрүүч Цэдэн-Ишийн Золбообаяр тодорсон билээ.

Дэд түрүүч Ц.Золбообаяр нь Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын харьяат, 2019-2020 онд Хилийн цэргийн 0165 дугаар ангид хугацаат цэргийн албаа үлгэр жишээ хааж, 2020 оны 10 дугаар сараас Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид цэргийн гэрээт алба хаагчаар үүрэг гүйцэтгэж байна. Түүнээс Хуурай замын цэргийн хүрээнд 2022 оны "Тэргүүний цэргийн гэрээт алба хаагч" болсон баярын сэтгэгдлээс хуваалцахад "Хуурай замын цэрэг хэмээх их айлын 2022 оны нэгэн шилдэг нь болж

чадсандаа баяртай байна. Цэргийн гэрээт алба хаах эрх зүйн орчин нөхцөл, боломж бололцоог нэмэгдүүлэхийн зэрэгцээ ажил, албандаа гүйцэтгэсэн үүрэг, оролцоогоор нь шагнаж буйд талархалтай байгаа. 2022 он миний хувьд завгүй хөдөлмөрлөсөн жил байлаа. Дөрөвдүгээр сараас аравдугаар сар хүртэл төмөр замын бүтээн байгуулалт болон Дархан-Уул аймаг Улаанбаатар хотын чиглэлийн хатуу хучилттай замын бүтээн байгуулалтад бусад нөхдийнхөө хамтаар оролцож, анги байгууллагынхаа бүтээлч ажил, уралдаан тэмцээнд тодорхой амжилтууд үзүүлээ. Миний цаашдын зорилго үүрэг гүйцэтгэх чадавх, хувь хүний хөгжилдөө илүү анхаарах бөгөөд үүний тулд дарга нарынхаа зааж сургасан бүхнийг өөрийн болгохоор

хичээж байна" гэсэн юм.

Тэрээр цэргийн гэрээт алба хаагчдад олон боломж нээлттэй байдаг. Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх, улс орны томоохон бүтээн байгуулалтад оролцох, сургалт дамжаанд хамрагдах гээд нэрлэж болно. Үүний нэг жишээг өөрөөрөө харуулж, бүтээн байгуулалтад оролцоо хэмээн тодотгож, ажил албаараа манлайлахыг нөхдөдөө уриалав.

Ярилцлагынхаа төгсгөлд дэд түрүүч маань Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумандаа ажиллаж амьдран суугаа аав Д.Цэдэн-Иш, ээж С.Олзбаяр, ах эгч, дүү нартаа өвлийн дунд сарын мэндийг уламжилж, зуд турхангүй өнтэй сайхан өвөлжихийг ерөөлөө.

Ахмад Д.БОЛОР


Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №52



ША ҮСЭГ БҮХИЙ УНШИХ, БИЧИХ ДАДЛАГА
ША үсэг бүхий, уншихад хялбар, нэг юм уу хоёрхон үеэс бүтсэн, бичлэг дуудлага нь өнөөгийнхтэй үндсэндээ таардаг хялбар жишээ үгсийг унших, бичих дасгал дадлага хийцгээе. Зөв уншаад, хичээнгүй сайхан бичиж, кириллээр хөрвүүлээрэй.

Дармал, бичмэл тигээр:



Хошууч генерал Ч.Самбуугийн нэрэмжит, Алтангадас одонт Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн бүрэлдэхүүн "Цусаа хандивлах үндэсний өдөр"-ийг тохиолдуулан бусдад амьдрал бэлэглэх сайн үйлсийн аянд нэгдлээ.

Бусдад амьдрал бэлэглэх аянд хугацаат цэргийн алба хаагчид өөрсдийн хүсэлтээр хамрагдаж буйд Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс талархал илэрхийлж, "Эх орноо батлан хамгаалагч эр цэргүүд та нар энэ үйлсээрээ том гавьяа байгуулж байна. Бусдын алтан амийг аварна гэдэг дайны талбарт нөхөртөө тусалсантай адил

баатарлаг үйлс, хэзээ ч мартагдахгүй мөнхийн гавьяа юм. Жил бүрийн 1 дүгээр сарын 3-ны өдрийг "Цусаа бэлэглэх үндэсний өдөр" болгосноос хойш 7 дахь жилдээ тэмдэглэн өнгөрүүлж байна. Энэ өдрийн гол зорилго нь цусны доноруудыг алдаршуулах, донорын үйлсийг олон нийтэд сурталчлахад оршдог. Цэргийнхний сайн үйлсийн аяныг түүчээлж, Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн бие бүрэлдэхүүн нэгдсэн явдалд талархал илэрхийлье" гэсэн юм.

Дэслэгч Б.ОЮУНБИЛЭГ